



## ХӨСҮТ

- Төвийн түүхэн товчоо
- Төвийн бүтэц
- Төвийн үндсэн чиг үүрэг ▾
- Төсөв санхүү
- Төвийн алба тасгууд
- Төвийн үйлчилгээ
- ХӨЭСХАХА
- Хүний нөөц
- Ёс зүйн хороо
- Утасны жагсаалт

## Зөвлөгөө

- Эрүүл мэнд ба тархвар зүй
- Менингококкт халдвар
- Дархлаажуулалт
- ДОХ/БЗДХ ▾
- Сүрьеэ ▾
- Гепатит
- Зоонозын халдвар ▾
- Амьсгалын замын цочмог халдвар ▾
- Гэдэсний халдвар
- Гар хөл амны өвчин
- Тууралтат халдвар
- Хаана хандах вэ?

2013 оны 8-р сарын 12, Даваа гариг, 17:12



### Шинэ Зеландын “Хортой” сүүний талаарх мэдээлэл

Шинэ Зеланд улсын “Fonterra” компанид 2012 оны тавдугаар сард үйлдвэрлэгдсэн “WPC80” код бүхий шар сүүний уургийн хатаасан бэлдмэл Clostridium botulinum нянгаар бохирдсон талаар олон улсын хэвлэл мэдээллээр мэдээлж байгаа. Үүнтэй холбогдуулан МХЕГ-ын даргын гаргасан удирдамжийн дагуу дээрх бэлдмэлээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн манай улсад худалдаалагддаг эсэх талаар судалгаа явуулж байгаа юм.

Шинэ Зеланд улсын “Fonterra” компанид үйлдвэрлэсэн “WPC80” код бүхий шар сүүний уургийн хатаасан бэлдмэлийг ашиглан БНХАУ, Малайз, Вьетнам,

Тайланд, Саудын Араб, Австрали, Шинэ Зеланд улсад үйлдвэрлэсэн хүүхдийн сүүн тэжээл, өндөр хэмд ариутгасан ундны сүү, йогурт, тамирчдад зориулсан уургийн бэлдмэл, шар сүүний уургийн хатаасан бэлдмэл зэрэг нь Монгол улсад орж ирдэггүй гэж Гаалийн Ерөнхий газраас мэдээлжээ.

Энэхүү мэдээллийг баталгаажуулах үүднээс нэр заагдсан улсад үйлдвэрлэгдсэн хүүхдийн сүүн тэжээл, ундны ариутгасан сүү, йогурт, тамирчдад зориулсан уургийн бэлдмэл худалдаалж буй эсэхийг шалгахар Нарантуул, Тэнгэр, Хархорин, Бөмбөгөр худалдааны төв, Замбала, Экстра, Скай, Оргил, Номин зэрэг есөн худалдааны төвд судалгаа хийгээд байгаа аж. Эдгээр газруудад дээрх орны нэр заагдсан бүтээгдэхүүн худалдаалагдаагүй байна.

Шинэ Зеланд улсын “Fonterra” компанид үйлдвэрлэсэн хуурай сүүг авч ашигладаг АПУ, Витафит-Инвест, Тэсо зэрэг ХХК-ууд нь бүтээгдэхүүндээ шар сүүний уураг ашигладаггүй байна. Эдгээр газруудын үндсэн түүхий эд болох хуурай сүүнээс дөрвөн дээж, бэлэн бүтээгдэхүүн болох савласан сүүнээс дөрвөн дээж авч, стандартын шаардлага хангаж буй эсэхэд дүгнэлт гаргахаар МХЕГ-ын лабораторид шинжлүүлэхээр өгчээ. Мөн “Цаст фүүдс” ХХК нь Хятад улсын “Менгниу” группын албан ёсны дистрибьютер бөгөөд Хөх хот дахь салбараас “Монмилк” нэрийн таван төрлийн савласан шингэн сүүг оруулж ирэн, мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлттэйгээр худалдаалж байна. Дээрх таван төрлийн ундны сүүнээс дээж авч шинжилгээнд хамруулаад байгаа аж.

ХӨТСА